



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/395

Ховд

Г Хэсэгчилсэн хөл хориог цуцлах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 09 дүгээр шийдвэрийг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт тарваган тахал өвчний тохиолдол гарсантай холбогдуулан аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг, Цэцэг сумын Хүн эмнэлэгт тогтоосон хорио цээрийн дэглэмийг 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 16.00 цагаас эхлэн цуцалсугай.

2. Хэсэгчилсэн хөл хориог цуцалсантай холбогдуулан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг, Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн байранд ариутгал, халдваргүйтгэл хийж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /П.Улаанхүү/, Зоонозын өвчин судлалын төв /Б.Баяржаргал/, Цэцэг сумын Эрүүл мэндийн төв /Н.Солонго/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/352 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН